

Солонгос хэлний хөтөлбөр

Хангён үндэсний их сургууль нь нийслэлийн ойролцоо хэсэгт байрладаг үндэсний их сургууль бөгөөд глобал эрин үеийг манлайлах практик, хосолмол байдалд тулгуурласан боловсрол олгодог.

Гадаадын оюутнууд болон олон улсын солилцоог дэмжих системтэй боловсролын орчинг бүрдүүлсэн бөгөөд, тогтвортой сургалтын үйл ажиллагаа болон оюутан төвтэй системээрээ итгэл хүлээсэн боловсролын байгууллага болон хөгжиж байна.



Ялангуяа солонгос хэлний хөтөлбөр нь солонгос хэлний чадварыг нэмэгдүүлээд зогсохгүй, солонгосын нийгэм соёлд аажмаар дасан зохицоход чиглэн боловсруулсан албан ёсны сургалтын хөтөлбөр хэлбэрээр хэрэгждэг. Мэргэжлийн солонгос хэлний багш нар, шаталсан сургалтын хөтөлбөр, төрөл бүрийн соёлын практик үйл ажиллагаагаар дамжуулан суралцах үр дүнг дээд хэмжээнд хүргэдэг.

Хангён үндэсний их сургууль нь глобал боловсон хүчин солонгост суралцаж ирээдүйдээ бэлдэхэд дэмжлэг үзүүлж найдвартай хамтрагч байх болно.



• Ажилд орох хувиараа 3 жил дарааллан 1-р байр

Үндэсний их сургуулиуд дундаа
3 жил дарааллан 1- байр эзэлсэн

• Ажлын байрны гүүр хөтөлбөрт 5 жил дарааллан сонгогдсон

Гёнгү аймгийн оюутны ажлын байрны
гүүр хөтөлбөрт оролцогч их сургууль

• Гадаад оюутны тэтгэлэг

Солонгос хэлний түвшин тогтоох
шалгалт(ТОПИК)-ын оноотой
тохиолдолд элсэх үед нь тэтгэлэг олгоно

• Сөүлээс 1 цагийн зайтай

Солонгосын нийслэл Сөүл хоттой ойрхон
Гёнгү аймагт байрлах Гёнгү аймгийн
цорын ганц үндэсний их сургууль

Солонгос хэлний хөтөлбөр

Хангён Үндэсний их сургуулийн солонгос хэлний хөтөлбөр (Korean Language Program, KLP) нь гадаад оюутнуудад зориулан солонгос хэлний чадвар дээшлүүлэх, солонгосын нийгэм соёл дасан зохицоход дэмждэг үзүүлэх албан ёсны хөтөлбөр юм. Олон улсын хамтын ажиллагааны төвөөс улирал бүр системтэй солонгос хэлний боловсрол олгож байна. Хичээл нь сонсох, ярих, унших, бичихэд тулгуурлан шатласан байдлаар явагдана. Солонгосын соёлыг мэдрэх болон оюутны амьдралд дасан зохицоход туслах төрөл бүрийн хөтөлбөрийг хамтад нь хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь солонгос хэлний чадварыг дээшлүүлэхээс гадна цаашид их сургуульд дэвшин суралцахад бэлдэх суурь хөтөлбөр болдог.

хураангуй

Хичээлийн хуваарь

10 долоо хоног
(Даваа~Баасан)
9:00 ~ 12:50
or 14:00 ~ 17:50

Төлбөр

1,200,000вон(KRW)
(1 улиралд)

Бүртгэлийн хураамж

50,000вон

Дотуур байр

450,000вон(KRW)
(өдрийн 2 хоол заавал
сонгох / өдрийн 3
хоолноос 2-г сонгох
боломжтой)

* Эхний улирлийн бүртгэл хийлгэхдээ заавал 2-оос дээш улирлын төлбөр төлнө, сурах бичиг багтаагүй


Тавигдах шаардлага

Бүрэн дунд сургууль төгссөн(төгсөх гэж байгаа) эсвэл түүнтэй дүйцэхүйц боловсрол эзэмшсэн гадаад иргэн болон солонгос гаралтай гадаад иргэн

2026 оны хөтөлбөрийн хуваарь

Улирал	Бичиг баримт хүлээн авах хугацаа(Гадаадад оршин суугч)	Хөтөлбөрийн хугацаа
Хавар	2026.01.19.Даваа	2026.03.03.Мягмар ~ 2026.05.12.Мягмар
Зун	2026.04.03.Баасан	2026.05.26.Мягмар ~ 2026.08.03.Даваа
Намар	2026.07.17.Баасан	2026.09.01.Мягмар ~ 2026.11.13.Баасан
Өвөл	2026.10.16.Баасан	2026.12.01.Мягмар ~ 2027.02.12.Баасан

Солонгос хэлний хөтөлбөр



Хүсэлт гаргах шатлал



Бүрдүүлэх бичиг баримт

- Элсэлтийн өргөлөл, Цээж зураг 1 хувь, Гадаад паспортын хуулбар
- Төрөл садангийн лавлагаа эх хувь
- Хамгийн сүүлд төгссөн сургуулийн диплом болон дүнгийн тодорхойлолт
 - Апостиль(Apostille) гэрчилгээ эсвэл консулын баталгаа хийлгэх шаардлагатай
- Банкны дансны үлдэгдлийн тодорхойлолт эх хувь (KRW 10,000,000-с дээш)
 - Сүүлийн 30 хоногийн дотор авсан тодорхойлолтыг зөвхөн хүлээн зөвшөөрнө
 - 3-с дээш сар үлдэгдлээ хэвээр байлгахыг зөвлөж байна
- (Холбогдох тохиолдолд) Өөрийн болон эцэг эхийн ажлын газрын тодорхойлолт болон орлогын тодорхойлолтын хуулбар / (Холбогдох тохиолдолд) Солонгос иргэний батлан даалт

ТЭТГЭЛЭГ

	Дүнгийн тэтгэлэг	Ирцийн тэтгэлэг	ТОПИК-н тэтгэлэг
Хамрагдах хүн	Өмнөх улиралд өндөр амжилттай суралцсан суралцагч	Онц сурлагатай бөгөөд 100% ирцтэй суралцагч	Солонгос хэлний хөтөлбөрт суралцаж байх үедээ ТОПИК 3-с дээш түвшний оноо авсан суралцагч
шаардлага	Улирал бүр анги болон түвшин бүрийн шилдэг суралцагч	Хичээлдээ 100% ирцтэй суралцсан суралцагч	
Хэмжээ	100,000вон ~ 300,000вон	Эхний улирал 100,000вон (Дээд тал нь 500,000вон хүртэл олгоно)	ТОПИК 3-р түвшин, эсвэл нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн түвшин тогтоох шалгалтын 4-р шат : 500,000вон
			ТОПИК 4-с дээш түвшин, эсвэл нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн түвшин тогтоох шалгалтын 5-с дээш шат : 1,000,000вон

HKNU кампусын ерөнхий зураг



Холбоо барих мэдээлэл

Хаяг	Room 505, AI Future Bldg., Hankyong National University, 327 Jungang-ro, Anseong-si, Gyeonggi-do, 17579
Утас	+82 31-670-5492~3 (Солонгос хэлний хөтөлбөр хариуцсан ажилтны дотоод утас)
Факс	+82 31-670-5499
Цахим шуудан	intercenter@hknu.ac.kr
Вэб хаяг	www.global.hknu.ac.kr